



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

Төлбөр тооцооны шинэ системд
шилжих бэлтгэл ажлын хүрээнд авах
арга хэмжээний тухай

Үнэт цаасны зах зээлийн арилжаа, төлбөр тооцооны горимын шинэчлэл хийгдэж байгааг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны “Миллениум Ай Ти” системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлын хүрээнд харилцагч, хөрөнгө оруулагчдаас үнэт цаас худалдан авахаар “ҮЦТТТХТ” ХХК-д урьдчилан байршуулсан мөнгөн хөрөнгийг харилцагч, хөрөнгө оруулагч тус бүрийн арилжааны банк дахь дансанд буцаан байршуулах арга хэмжээ авахыг “ҮЦТТТХТ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /М.Болд/-д үүрэг болгосугай.

2. Харилцагч, хөрөнгө оруулагчдын буцаан байршуулах боломжгүй үлдэгдэл мөнгөн хөрөнгийг зөвхөн тухайн харилцагч мөнгө хүссэн өргөдөл гаргах хүртэлх хугацаанд “ҮЦТТТХТ” ХХК өөрийн дансанд байршуулахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

3. Систем шинэ горимд шилжих өдрүүдэд харилцагчдын данс нээх болон нөхцөлт захиалга биелэгдэх боломжгүй тухай мэдээллийг харилцагчиддаа хүргэж ажиллахыг нийт брокер, дилерийн компаниудад үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН